

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2026/33/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 260512 Цахим хаяг: erdenetsogtb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Отгонцэцэг Утас: 261628 Цахим хаяг: otgontsetsegb@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Утас: 976-91910954 Цахим хаяг: dabg.audit@gmail.com</p>
------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	17
3.5.3 Нэмэлт төсөв.....	18
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	18
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	22
5.1 Албан шаардлага	22
5.2 Зөвлөмж	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
СБТ	Санхүүгийн байдлын тайлан
СС	Сангийн сайд
СЯ	Сангийн яам
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТУХ	Төслийн удирдах хороо
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

МОНГОЛ УЛСАД КОВИД-19 ХАЛДВАРААС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ,
БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ С.ЭНХБОЛД ТАНАА

2026.04.02 № 06/327
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 96,290.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

Гадаад томилолтын бүрэлдэхүүнд тус төслийн үйл ажиллагаатай хамааралгүй бусад яам, газрын албан тушаалтнууд хамрагдаж, 96,268.2 мянган төгрөгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 6 дугаар зүйлийн 6.6.6, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.7 заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийг 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газар болон Олон улсын хөгжлийн ассоциаци, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд анх хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн хэлэлцээр байгуулсан.

Зээлийн гэрээний хугацаанд зарцуулаагүй санхүүжилтийн үлдэгдлийг бүрэн зарцуулахаар талууд тохиролцсоны дагуу гэрээнд өөрчлөлт оруулан төслийн хугацааг 2 удаа сунгаж, 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөр бүрэн хэрэгжиж, төсөл хаагдсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрүүл мэндийн яам Эс Ай Си Эй ХХК-тай 2024 оны 10 дугаар сараас 2025 оны 2 дугаар сар хүртэл “Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн хүрээнд худалдан авч, нийлүүлсэн тоног төхөөрөмжийн үр ашгийн судалгаа” хийх зөвлөх үйлчилгээний CS-10, T/69 дугаартай гэрээг байгуулан 347,847.8 мянган төгрөгийг зарцуулсан.

Судалгаанд Улаанбаатар хотын 18, орон нутгийн 188, нийт 206 эмнэлгийг хамруулсан бөгөөд төслөөс нийлүүлсэн тоног төхөөрөмжийг хүлээн авсан байдал, хүргэлт, суурилуулалтын чанар, зохион байгуулсан сургалтын үр дүн, тоног төхөөрөмжийн чанарын баталгааны нөхцөл байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамж, ашиглалтын нөхцөл байдал зэрэг мэдээллийг цуглуулж, үр дүнг нэгтгэн тайлагнасан байна.

Бусад асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Гадаад зээл, тусламжийн төслүүдийн үр ашиг, бүтээмжийг сайжруулах хүрээнд авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 24 дүгээр тогтоол, Ерөнхий сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгаврын 7.8-д гадаад зээл, тусламжийн төслүүдийг эрэмбэлэх, хэрэгжилт, ашиглалтыг сайжруулах, төслийн менежментийн тогтолцоонд өөрчлөлт оруулж, тусгайлсан төслийн нэгжүүдийг Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохион байгуулалтад шилжүүлэх ажлыг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,351,924,976.69	22,197.42
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,088,180,461.24	22,197.42
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	5,088,180,461.24	22,197.42
31210	Төгрөг	3,132,061,846.57	-
31211	Төрийн сангийн харилцах	3,132,061,846.57	-
31220	Гадаад валют	1,956,118,614.67	22,197.42
31221	Төрийн сангийн харилцах	1,956,096,417.25	-
31223	Арилжааны банк дахь харилцах	22,197.42	22,197.42
34	Урьдчилгаа	5,263,744,515.45	-
34600	Урьдчилж гарсан зардал	5,263,744,515.45	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	53,130,286.14	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	53,130,286.14	-
39200	Биет хөрөнгө	53,130,286.14	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	132,727,272.73	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(92,909,090.91)	-
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	101,974,567.56	-
39206	Хуримтлагдсан элэгдэл	(95,994,579.26)	-
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,186,156.16	-
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,854,040.14)	-
39301	Програм хангамж	6,520,000.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,520,000.00)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	10,405,055,262.83	22,197.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,440,913,086.33	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,440,913,086.33	-
41300	Өглөг	1,440,913,086.33	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,440,913,086.33	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,964,142,176.50	22,197.42
51	Засгийн газрын хувь оролцоо	8,964,142,176.50	22,197.42
51200	Хуримтлагдсан үр дүн	8,964,142,176.50	22,197.42
51210	Өмнөх үеийн үр дүн	5,885,672,153.89	8,964,142,176.50
51220	Тайлант үеийн үр дүн	3,078,470,022.61	(8,964,119,979.08)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	10,405,055,262.83	22,197.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	24,270,353,383.61	82,148,613.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,270,353,383.61	82,148,613.16
120	Нийтлэг татварын бус орлого	24,270,353,383.61	2,919,113.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,270,353,383.61	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,500,000.00	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	24,267,853,383.61	-
120009	Бусад орлого	-	2,919,113.16
122	Тусламжийн орлого	-	79,229,500.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	79,229,500.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	79,229,500.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	79,229,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,984,727,910.42	2,020,127,787.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,984,727,910.42	2,020,127,787.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,984,727,910.42	2,020,125,171.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,534,847.59	112,529,013.47
210101	Үндсэн цалин	342,534,847.59	112,529,013.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,778,953.45	14,019,500.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	-	9,533,240.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	-	1,121,560.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	-	560,800.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	-	560,800.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	42,778,953.45	2,243,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	104,135,086.71	29,809,192.46
210304	Байрны түрээс	104,135,086.71	29,809,192.46
2104	Хангамж, бараа материалын зардал	15,694,153.65	2,804,164.86
210401	Бичиг хэрэг	2,891,465.48	900,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,450,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,156,075.17	1,366,514.86
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,196,613.00	537,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,472,799.96	657,800.00
210604	Урсгал засвар	13,472,799.96	657,800.00
2107	Томилолт, зочны зардал	29,621,865.91	170,798,552.54

Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210701	Гадаад албан томилолт	-	160,447,051.54
210702	Дотоод албан томилолт	29,621,865.91	8,565,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	1,786,501.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,399,345,088.16	640,298,903.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,380,309,192.46	620,218,903.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,000,000.00	20,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	131,920.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	174,048.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,627,409.00	-
210808	Банкны шимтгэл	102,518.70	80,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,145,114.99	1,049,208,044.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,159,000.00	1,049,208,044.49
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,986,114.99	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,616.10
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	2,616.10
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	2,616.10
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	2,616.10
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	2,616.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	22,285,625,473.19	(1,937,979,174.06)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	62.04	35,222,304.32
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	62.04	35,222,304.32
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	19,207,155,512.62	7,061,363,109.34
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	53,130,286.14
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	20,077,120.31	6,223,751.08
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	19,187,078,392.31	7,002,009,072.12
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(19,207,155,450.58)	(7,026,140,805.02)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	3,078,470,022.61	(8,964,119,979.08)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	8,617,900,898.63	82,148,613.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,617,900,898.63	82,148,613.16
120	Нийтлэг татварын бус орлого	8,617,900,898.63	2,919,113.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,615,400,898.63	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	8,615,400,898.63	-
120009	Бусад орлого	2,500,000.00	2,919,113.16
122	Тусламжийн орлого	-	79,229,500.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	79,229,500.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	79,229,500.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	79,229,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,111,121,481.89	1,541,982,173.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,111,121,481.89	1,541,982,173.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,111,121,481.89	1,541,979,557.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	343,204,967.59	112,529,013.47
210101	Үндсэн цалин	343,204,967.59	112,529,013.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,778,953.45	14,019,500.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	31,118,396.37	9,533,240.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	2,065,014.68	1,121,560.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,014,875.74	560,800.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	412,998.93	560,800.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	7,167,667.73	2,243,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,589,632.17	28,354,646.96
210304	Байрны түрээс	105,589,632.17	28,354,646.96
2104	Хангамж, бараа материалын зардал	15,694,153.65	2,966,343.86
210401	Бичиг хэрэг	2,891,465.48	900,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,450,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,156,075.17	1,366,514.86
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,196,613.00	699,829.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,472,799.96	657,800.00
210604	Урсгал засвар	13,472,799.96	657,800.00
2107	Томилолт, зочны зардал	29,621,865.91	170,798,552.54
210701	Гадаад томилолт	-	160,447,051.54
210702	Дотоод албан томилолт	29,621,865.91	8,565,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	1,786,501.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,553,600,109.16	485,881,703.30

Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,534,666,732.16	465,801,703.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,000,000.00	20,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	131,920.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	174,048.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,627,409.00	-
210808	Банкны шимтгэл	-	80,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,159,000.00	726,771,996.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,159,000.00	726,771,996.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,616.10
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	2,616.10
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	2,616.10
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	2,616.10
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	2,616.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,506,779,416.74	(1,459,833,560.03)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	9,574,754,736.54	3,663,547,008.11
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,574,754,736.54	3,663,547,008.11
2200	Дотоод эх үүсвэрээр	9,574,754,736.54	3,663,547,008.11
222001	Тоног төхөөрөмж	9,574,754,736.54	3,663,547,008.11
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(9,574,754,736.54)	(3,663,547,008.11)
14	Бусад эх үүсвэр	62.04	35,222,304.32
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	62.04	35,222,304.32
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	20,077,120.31	-
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	20,077,120.31	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(20,077,058.27)	35,222,304.32
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(3,088,052,378.07)	(5,088,158,263.82)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,176,232,839.31	5,088,180,461.24

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	5,885,672,153.89	5,885,672,153.89
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	5,885,672,153.89	5,885,672,153.89
Тайлант үеийн үр дүн			3,078,470,022.61	3,078,470,022.61
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			8,964,142,176.50	8,964,142,176.50
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	8,964,142,176.50	8,964,142,176.50
Тайлант үеийн үр дүн			(8,964,119,979.08)	(8,964,119,979.08)
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	22,197.42	22,197.42

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	91,695,000.00	79,226,883.90	12,468,116.10	86.4
12	Татварын бус орлого	91,695,000.00	79,226,883.90	12,468,116.10	86.4
122	Тусламжийн орлого	91,695,000.00	79,226,883.90	12,468,116.10	86.4
122005	Төсвөөс санхүүжих	91,695,000.00	79,226,883.90	12,468,116.10	86.4
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,813,679,800.00	4,478,754,568.24	334,925,231.76	93.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,147,179,800.00	815,207,560.13	331,972,239.87	71.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,147,179,800.00	815,207,560.13	331,972,239.87	71.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	113,350,000.00	112,529,013.47	820,986.53	99.3
210101	Үндсэн цалин	113,350,000.00	112,529,013.47	820,986.53	99.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,019,600.00	14,019,500.00	100.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	9,533,300.00	9,533,240.00	60.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,121,600.00	1,121,560.00	40.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	560,800.00	560,800.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	560,800.00	560,800.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,243,100.00	2,243,100.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,745,000.00	28,354,646.96	390,353.04	98.6
210304	Байрны түрээс	28,745,000.00	28,354,646.96	390,353.04	98.6
2104	Хангамж, бараа материалын зардал	4,177,000.00	2,966,343.86	1,210,656.14	71.0
210401	Бичиг хэрэг	900,000.00	900,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,577,000.00	1,366,514.86	1,210,485.14	53.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	700,000.00	699,829.00	171.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	773,200.00	657,800.00	115,400.00	85.1
210604	Урсгал засвар	773,200.00	657,800.00	115,400.00	85.1
2107	Томилолт, зочны зардал	174,615,000.00	170,798,552.54	3,816,447.46	97.8
210701	Гадаад томилолт	164,050,000.00	160,447,051.54	3,602,948.46	97.8
210702	Дотоод албан томилолт	8,565,000.00	8,565,000.00	-	100.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,000,000.00	1,786,501.00	213,499.00	89.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	811,500,000.00	485,881,703.30	325,618,296.70	59.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	791,500,000.00	465,881,703.30	325,618,296.70	58.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	20,000,000.00	20,000,000.00	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,666,500,000.00	3,663,547,008.11	2,952,991.89	99.9
222001	Тоног төхөөрөмж	3,666,500,000.00	3,663,547,008.11	2,952,991.89	99.9

Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(4,721,984,800.00)	(4,399,527,684.34)	(322,457,115.66)	93.2
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,721,984,800.00	4,399,527,684.34	322,457,115.66	93.2
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	4,399,527,684.34	(4,399,527,684.34)	-
72	ЗГ-ын зээл	4,721,984,800.00	-	4,721,984,800.00	-
722	Гадаад	4,721,984,800.00	-	4,721,984,800.00	-
7221	Төслийн зээл	4,721,984,800.00	-	4,721,984,800.00	-
322101	Шинээр авах	4,721,984,800.00	-	4,721,984,800.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,088,180,461.24	(5,088,180,461.24)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	22,197.42	(22,197.42)	-
6	Тохируулах орлого		688,630,579.48		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газар болон Олон улын хөгжлийн ассоциаци, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр тус тус байгуулсан 6594-MN, 9082-MN дугаартай санхүүжилтийн хэлэлцээр, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан 6833-MN дугаартай нэмэлт санхүүжилтийн хэлэлцээрийн хүрээнд Эрүүл мэндийн яам хариуцан Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийг 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл хугацаанд хэрэгжүүлсэн.

Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл нь КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах Монгол Улсын чадавхыг бэхжүүлэх, нийгмийн эрүүл мэндийн бэлэн байдлын үндэсний тогтолцоог бэхжүүлэх зорилготой. Төслийн үйл ажиллагаа нь дараах үндсэн чиглэлтэй байна. Үүнд:

- Бүрэлдэхүүн хэсэг 1. КОВИД-19 вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ба хариу арга хэмжээ авах;
- Бүрэлдэхүүн хэсэг 2. Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх;
- Бүрэлдэхүүн хэсэг 3. Хэрэгжүүлэх удирдлага, хяналт-шинжилгээ ба үнэлгээ

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2024 оны 6 дугаар сард 6 дугаар зүйлийн 6.2.7-д “төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх”;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, тайлбар, зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”
- Сангийн сайдын 2025 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”

- Сангийн сайдын 2025 оны 174 дүгээр тушаалаар баталсан “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам”-ыг баталсан байна.

Төслийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаанд Дэлхийн банкны явцын хяналтууд хийгдэж, харьяа яамны хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузул сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн өдөр тутмын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх” журмыг мөрддөг бөгөөд төслийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Төслийн үйл ажиллагаа 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөр дуусвар болж, санхүүгийн үйл ажиллагаа 09 дүгээр сарын 19-ний өдөр хүртэл үргэлжилсэн байна. Төрийн банкны харилцах дансны үлдэгдлийг хаагаагүй 22.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,088,180.5	22.2	(5,088,158.3)
Урьдчилж гарсан зардал	5,263,744.5	-	(5,263,744.5)
Үндсэн хөрөнгө	53,130.3	-	(53,130.3)
Нийт хөрөнгө	10,405,055.3	22.2	(10,405,033.1)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,440,913.1	-	(1,440,913.1)
Хуримтлагдсан үр дүн	8,964,142.2	22.2	(8,964,120.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	10,405,055.3	22.2	(10,405,033.1)

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал, бараа үйлчилгээний зардлын өглөг, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 22.2 мянган төгрөг болж 5,088,158.3 мянган төгрөгөөр буурсан байна. Үүнд:
 - Зөвлөх үйлчилгээ, тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээнүүдийн үлдэгдэл төлбөрт 4,078,103.9 мянган төгрөг, үйл ажиллагааны дансанд 314,224.4 мянган төгрөгийг шилжүүлэн томиллолт, төслийн хаалтын үйл ажиллагаанд тус тус зарцуулсан;
 - Дэлхийн банканд зарцуулаагүй санхүүжилтийн үлдэгдэл 723,932.9 мянган төгрөгийг буцаан шилжүүлсэн;
 - Тусгай дансны өмнөх үлдэгдлээс 35,222.3 мянган төгрөгийн ханшийн зөрүүгийн бодит бус олз үүссэн нь нөлөөлсөн;
2. Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 5,263,744.5 мянган төгрөгөөр буурсан нь бэлтгэн нийлүүлэгч, хувь зөвлөхүүдийн гэрээний гүйцэтгэлийг дүгнэсэнтэй холбоотой урьдчилгаа төлбөр 4,941,308.5 мянган төгрөгийг зардлаар бүртгэж, НҮБ-ийн хүүхдийн сангийн гэрээний дүнгээс хийгдээгүй ажлын санхүүжилт 322,436.0 мянган төгрөгийг Дэлхийн банканд буцаан шилжүүлсэнтэй холбоотой;
3. Бараа үйлчилгээний зардлын өглөг дансны үлдэгдэл 1,440,913.1 мянган төгрөгөөр буурсан нь гэрээний үлдэгдэл төлбөрүүдийг шилжүүлсэнтэй холбоотой;
4. Тайлант оны үр дүн 8,964,120.0 мянган төгрөг байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаад зээлээс 842,289.3 мянган төгрөг, үүнээс үйл ажиллагааны урсгал зардалд 342,289.3 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 500,000.0 мянган төгрөгийн зардлыг тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, батлуулсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг гадаад зээлээс 3,879,695.5 мянган төгрөг, улсын төсвөөс 91,695.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Энэ нь гадаад зээлийн санхүүжилтийн үлдэгдлийг ашиглахаар Дэлхийн банк харилцан зөвшилцсөний дагуу ТУХ-оос 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан баталсантай холбоотой байна. Төслийн зохицуулагч болон Санхүүгийн ажилтнууд 2025 оны 3-6 дугаар саруудад төслийн хаалтын санхүүгийн болон үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой улсын төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 79,226.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, бусад орлого 2,919.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Гадаад зээлийн санхүүжилтийн өмнөх оны үлдэгдэл 5,088,180.5 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,478,754.5 мянган төгрөг буюу 93.0 хувьтай байгаа нь урсгал төсвийн зарцуулалт 12,468.1 мянган төгрөг, гадаад зээлийн зарцуулалт 322,457.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70207-Гадаад зээлээр хэрэгжүүлэх хөтөлбөр	4,813,679.8	4,478,754.5	334,925.2	93.0
1.1	80101-Үндсэн үйл ажиллагаа	91,695.0	79,226.8	12,468.1	86.4
1.3	80104-Гадаад зээлээр санхүүжих арга хэмжээ	4,721,984.8	4,399,527.7	322,457.1	93.2

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

1. Байгууллагын орон тооны цомхотголын талаар:

Төслийн нэгжийн батлагдсан орон тоо 7, гүйцэтгэлээр 1-2 дугаар саруудад 7, 3-6 дугаар саруудад 2 хүнтэй ажилласан байна. Батлагдсан цалингийн зардлын төсөв 106,200.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 112,529.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүнгийн талаар:

Тайлант онд төслийн хаалтын хурал зохион байгуулж 32,136.5 мянган төгрөгийн батлагдсан төсвөөс 29,790.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3. Гадаад томилолтын талаар:

Тайлант онд гадаад томилолтын 1 арга хэмжээний зардалд 182,087.9 мянган төгрөгийн төсөв баталж, 10 хүнийг хамруулан 160,447.1 мянган төгрөгийг зарцуулсан.

4. Программ хангамжийн бүртгэл, тайлагналын талаар:

Төслийн нэгжийн 6,550.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программыг ТӨБЗГ-ын 2025 оны 223 дугаар тогтоолоор ССАЖЗЯ-нд балансаас балансад шилжүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн хаалтын тайланд төслийн үр дүнг дараах байдлаар тайлагнасан. Үүнд:

- 41 багц үйл ажиллагааг төлөвлөснөөс хэрэгжилтийн гүйцэтгэл 98.3 хувь
- Төслийн санхүүжилтийн нийт зарцуулалт 98.0 хувь
- Төслийн үр дүнгийн 14 шалгуур үзүүлэлтийн 13 нь 100.0 хувь биелсэн.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилт	Төсөв	Зардал
1	Бүрэлдэхүүн 1: КОВИД-19 вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ба хариу арга хэмжээ авах	2020-2025	100.0	97.8	2,528,589.43	2,118,230.43
2	Бүрэлдэхүүн 2: Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх	2020-2025	100.0	98.3	225,905,161.34	221,871,787.34
3	Бүрэлдэхүүн 3: Хэрэгжүүлэх удирдлага, хяналт-шинжилгээ ба үнэлгээ	2020-2025	100.0	98.3	2,725,372.21	2,701,251.25
Дүн					231,159,122.98	226,691,269.02

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төслийн удирдах хорооны 2025 оны 14 дүгээр тогтоолоор тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 140,500.0 мянган төгрөгийн 4 бараа шууд худалдан авахаар баталж, 75.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4: Төлөвлөгөөний гүйцэтгэл:

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл			Зөрүү	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь	Тоо	Дүн
1	Бараа	4	140,500.0	3	73,462.8	75.0	1	67,037.2
Дүн		4	140,500.0	3	73,462.8	75.0	1	67,037.2

ЗӨСҮТ-ийн 58,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Вирус судлалын лабораторийг бэхжүүлэх” мэдээллийн технологийн нэвтрэх системийн худалдан авалт хийгдээгүй. ЗӨСҮТ-ийн “Вирус судлалын лабораторийг бэхжүүлэх” тавилга, хөшиг, компьютер худалдан авах 3 гэрээний үнийн дүнгээс 9,037.2 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төрийн банкин дахь харилцах дансыг хааж, төслийн хаалтын үйл ажиллагаанд нийцүүлэх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн аудитор Э.Цэрэннадмид гүйцэтгэж, захирал Н.Дэлгэрмаа, чанарын хяналтын менежер Д.Эрдэнэчимэг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Отгонцэцэг, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 6 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны төсвийн гүйцэтгэлийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны төсвийн гүйцэтгэлийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 4,478,754.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 44,787.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд батлагдсан төсвийн хүрээнд төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 1 зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд байршуулах 165 мэдээлээс Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл–Хөтөлбөр, зориулалт, Байгууллагын батлагдсан төсөв, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан 25 мэдээг хугацаа хоцроон байршуулсан. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хууль 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай тус тус нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомж хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжтой нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар жилийн эцсийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг аудит хийлгэх хуулийн хугацаанд ирүүлээгүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллага, хувь хүмүүсийн төлбөр тооцооны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, зээлийн ашиглалтын тооцоог СЯ-ны холбогдох газар нэгжтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалт хийж төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй 4 зөрчилд албан шаардлага, шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй нийцлийн асуудлаар 1 зөвлөмж хүргүүлснээс 60.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Дд	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Зөвлөмж	1	-	-	-	0.0
2	Албан шаардлага	4	223,244,518.6	3	223,244,518.6	75.0
Нийт дүн		5	223,244,518.6	3	223,244,518.6	60.0

2025 оны жилийн эцсийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг аудит хийлгэх хуулийн хугацаанд ирүүлээгүй өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй асуудлаар өгсөн зөвлөмж тус тус хэрэгжээгүй тул албан шаардлага хүргүүлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дээд шатны төсөв захирагчаас дараах зөрчлийг арилгахад анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

- Төсөл хэрэгжих хугацааны худалдан авалтын гэрээ байгуулахад бэлтгэн нийлүүлэгчийн гаргасан гүйцэтгэлийн баталгааны бүртгэл ирүүлээгүй;
- Төсөл хаагдсаны дараа тайлагнах хугацаанд төслийн санхүү, нягтлан бодох бүртгэлийг хуулийн хугацаанд нь тайлагнаагүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 100,150.9 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд: Валютын ханшийг буруу тооцоолж, Дэлхийн банканд зээлийн буцаасан санхүүжилтийг 11.965.2 мянган төгрөгөөр илүү, 2,839.1 мянган төгрөгийн бусад орлого, урсгал төсвийн төвлөрүүлэх шилжүүлэг 2.6 мянган төгрөгийг тус тус дутуу, нийт 14,806.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
2. Мөнгөн гүйлгээний тайланд: Мөнгөн хөрөнгийн харилцах дансны хуулганы дүнгээс Дэлхийн банканд зээлийн буцаасан санхүүжилтийг 11.965.2 мянган төгрөгөөр илүү, 2,839.1 мянган төгрөгийн бусад орлого, урсгал төсвийн төвлөрүүлэх шилжүүлэг 2.6 мянган төгрөгийг тус тус дутуу, нийт 14,806.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
3. Урьдчилгаа данснаас НҮБ-ийн хүүхдийн сангийн буцаасан төлбөрийн ханшийн зөрүүгээр зээлийн хөрөнгөөр бэлдсэн тоног төхөөрөмжийн өртгийг 11,183.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
4. Бэлтгэн нийлүүлэгчийн өглөгийн дансны төлбөр тооцоог бүртгэхдээ валютын ханшийн зөрүүгийн бодит бус гарзыг 6,223.7 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон;
5. ТӨБЗГ-ын шийдвэрээр төслийн үндсэн хөрөнгийг шилжүүлэхдээ данснаас хассаны гарзыг 53.130.3 мянган төгрөгийг тодорхойлоогүй, ашиглаагүй хөрөнгөнд 48.784.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал, ханшийн зөрүүгийн гарзыг тус тус илүү тооцоолон бүртгэсэн.

Энэ нь УСНББОУС-1-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг” гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 96,290.4 мянган төгрөгийн 3 зөрчил илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 96,290.4 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 44,235.1 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай дүгнэлт” өглөө.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт-1: Төслийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 6 дугаар албан бичгээр хуульд заасан хугацааг хоцроож ирүүлсэн, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа

улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасантай тус тус нийцээгүй байна

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланг хуульд заасан хугацааг хоцроон ирүүлсэн зөрчлийг таслан зогсоох, цаашид зөрчлийг давтан гаргахгүй хууль тогтоомжийг биелүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт-2: Австрали улсын эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээг судлах айлчлалд 10 хүний 160,447.1 мянган төгрөгийн гадаад албан томилолтын зардал гарсан байна. Айлчлалын бүрэлдэхүүнд төсөлтэй хамааралгүй бусад яам, газрын нийт 6 хүний 96,268.2 мянган төгрөгийн зардлыг гаргаж, төслийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д “Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.7-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх” гэж заасантай тус тус нийцээгүй байна

Шийдвэрлэсэн нь: Гадаад албан томилолтын зардлаас бусад яам, газрын хүмүүсийн гадаад томилолтын зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, цаашид зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Зөвлөмж

Илрүүлэлт: Төрийн банкны 3416000076594 дугаартай харилцах дансанд 22.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, дансыг хаагаагүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн банкин дахь харилцах дансыг хааж, төслийн хаалтын үйл ажиллагаанд нийцүүлэх

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
								Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	<u>Санхүүгийн үр дүнгийн тайланд:</u> Валютын ханшийг буруу тооцоолж, Дэлхийн банкинд зээлийн буцаасан санхүүжилтийг 11.965.2 мянган төгрөгөөр илүү, 2,839.1 мянган төгрөгийн бусад орлого, урсгал төсвийн төвлөрүүлэх шилжүүлэг 2.6 мянган төгрөгийг тус тус дутуу, нийт 14,806.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	14,806.9			1	14,806.9	1	14,806.9				
2	<u>Мөнгөн гүйлгээний тайланд:</u> Мөнгөн хөрөнгийн харилцах дансны хуулгийн дүнгээс Дэлхийн банкинд зээлийн буцаасан санхүүжилтийг 11.965.2 мянган төгрөгөөр илүү, 2,839.1 мянган төгрөгийн бусад орлого, урсгал төсвийн төвлөрүүлэх шилжүүлэг 2.6 мянган төгрөгийг тус тус дутуу, нийт 14,806.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	14,806.9	1	14,806.9			1	14,806.9				
3	Урьдчилгаа данснаас НҮБ-ийн хүүхдийн сангийн буцаасан төлбөрийн ханшийн зөрүүгээр зээлийн хөрөнгөөр бэлдсэн тоног төхөөрөмжийн өртгийг 11,183.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	11,183.0			1	11,183.0	1	11,183.0				
4	Бэлтгэн нийлүүлэгчийн өглөгийн дансны төлбөр тооцоог бүртгэхдээ валютын ханшийн зөрүүгийн бодит бус гарзыг 6,223.7 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон.	1	6,223.7	1	6,223.7			1	6,223.7				
5	ТӨБЗГ-ын шийдвэрээр төслийн үндсэн хөрөнгийг шилжүүлэхдээ данснаас хассаны гарзыг 53.130.3 мянган төгрөгийг тодорхойлоогүй, ашиглаагүй хөрөнгөнд 48.784.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал, ханшийн зөрүүгийн гарзыг тус тус илүү тооцоолон бүртгэсэн.	1	53,130.3			1	53,130.3	1	53,130.3				
Дүн		5	100,150.9	2	21,030.6	3	79,120.2	5	100,150.9	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төслийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 6 дугаар албан бичгээр хуульд заасан хугацааг хоцроож ирүүлсэн, зөрчлийг давтан гаргасан байна.	1	-			1	-						
2	Австрали улсын эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээг судлах айлчлалд 10 хүний 160,447.1 мянган төгрөгийн гадаад албан томилолтын зардал гарсан байна. Айлчлалын бүрэлдэхүүнд төсөлтэй хамааралгүй бусад яам, газрын нийт 6 хүний 96,268.2 мянган төгрөгийн зардлыг гаргаж, төслийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан байна.	1	96,268.2			1	96,268.2						
3	Төрийн банкны 3416000076594 дугаартай харилцах дансанд 22.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, дансыг хаагаагүй байна.	1	22.2					1	22.2				
Дүн		3	96,290.4	-	-	2	96,268.2	1	22.2	-	-	-	-

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил													
1	Шилэн дансны цахим хуудсанд байршуулах 165 мэдээлээс Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл–Хөтөлбөр, зориулалт, Байгууллагын батлагдсан төсөв, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан 25 мэдээг хугацаа хоцроон байршуулсан. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	1	-					1	-				
Дүн		1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1172/АДИ50185

Улаанбаатар хот

САГ-2026/33/НА - СТА - ТХН

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Австрали улсын эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээг судлах айлчлалд 10 хүний 160,447,051.00 /Нэг зуун жаран сая дөрвөн зуун зөчин долоон мянга тавин нэгэн/ төгрөгийн гадаад албан томилолтын зардал гарсан байна. Айлчлалын бүрэлдэхүүнд төсөлтэй хамааралгүй бусад яам, газрын нийт 6 хүний 96,268,231.00 /Ерэн зургаан сая хоёр зуун жаран найман мянга хоёр зуун гучин нэгэн/ төгрөгийн зардлыг төслөөс гаргасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, 2026 оны 2 дугаар сарын 28-ны өдөр хаагдаж байгаа төслийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д "Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан", 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гадаад албан томилолтын зардлаас бусад яам, газрын хүмүүсийн гадаад томилолтын зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч /Н.Эрдэнэхүү/, Санхүүгийн ажилтан /Г.Тунгалагтамир/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Н.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-42.Docx

1576181828



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1173/A0150185

Улаанбаатар хот

САГ-2026/33/НА-СТА-ТХМ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах 165 мэдээллээс Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-Хөтөлбөр, зориулалт, Байгууллагын батлагдсан төсөв, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан 25 мэдээг хугацаа хоцроон байршуулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлдэггүй, зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч /Н.Эрдэнэхүү/, Санхүүгийн ажилтан /Г.Тунгалагтамир/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1174/A0150185

Улаанбаатар хот

SAG-2026/33/HA-СТА-ТХИ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төслийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 6 дугаар албан бичгээр хуульд заасан хугацааг хоцроож ирүүлсэн, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайланг хуульд заасан хугацаа хоцроож ирүүлсэн, зөрчлийг таслан зогсоох, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч /Н.Эрдэнэхүү/, Санхүүгийн ажилтан /Г.Тунгалагтамир/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Н.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-42.Docx

1526181832